



БАЯНХОНГОР АЙМГИЙН
ГУРВАНБУЛАГ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 01 сарын 02 өдөр

Дугаар 4/02

Пионер толгой

Г Галын аюулгүй байдлыг
ханган ажиллах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дүгээр зүйлийн 66.1, Галын аюулгүй байдлын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1 дэх заалтыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Өрх гэр, албан байгууллага бүр галын аюулгүй байдлыг ханган ажиллахыг албан байгууллагын дарга, эрхлэгч, иргэдэд даалгасугай.

2. Гудамж хороолол, аж ахуйн нэгжүүдийн цахилгааны аюулгүй байдлыг улирал бүр шалгаж, холбогдох арга хэмжээ авч ажиллахыг Эрчим хүчний байцаагч (Г.Бямба-Эрдэнэ), багийн Засаг дарга нарт үүрэг болгосугай.

3. Баяр ёслол, нийтийг хамарсан ажил арга хэмжээний үеэр хариуцлагатай жижүүр гарган ажиллах, байгаль цаг үеийн гэнэтийн үзэгдэл бусад хүчин зүйлээс шалтгаалан цахилгаан удаан хугацаагаар тасрах үед цахилгааны эх үүсвэрийн бэлэн байдлыг ханган ажиллахыг байгууллагын дарга, эрхлэгч нарт үүрэг болгосугай.



ДАРГА *Б.ГАНТУЛГА* Б.ГАНТУЛГА

642201149

Е/2023/Засаг дарга/Захирамж2023